



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫН ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№110 /554/

2023.07.18

Цаг үе, үйл явдал

"НҮҮДЭЛЧИН ЗААН-2023" СУРГАЛТ ДАДЛАГАД ОРОЛЦОХ БНЭУ-ЫН ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИД МОНГОЛ УЛСАД ГАЗАРДЛАА



Монгол, БНЭУ-ын хамтарсан "Нүүдэлчин заан" сургалт дадлагад оролцох Энэтхэгийн армийн цэргийн алба хаагчид тусгай үүргийн онгоцоор Монгол Улсад газардлаа.

Тус сургалт, дадлага нь жил бүр Монгол Улс, БНЭУ-ын газар нутаг дээр ээлжлэн зохион байгуулагдаж ирсэн бөгөөд энэ жил манай улсад явагдах уг сургалт, дадлагад Энэтхэгийн талаас

40 гаруй хүнтэй салааны бүрэлдэхүүн оролцох юм.

Энэхүү хамтарсан сургалт, дадлага нь хоёр орны цэргийн итгэлцлийг бэхжүүлэх, харилцан туршлага солилцох, бүс нутгийн аюулгүй байдлыг бататгахад чухал ач холбогдолтой арга хэмжээ бөгөөд энэ сарын сүүл хүртэл үргэлжлэх юм.



ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 20	☁️ 10

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 39	☁️ 26

ВАЛҮТЫН ХАНШ

ВАЛҮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3,426	3,432
EUR 🇪🇺	3,741	3,757
CNY 🇨🇳	476.80	478.50
RUB 🇷🇺	38.20	40
JPY 🇯🇵	22.60	23.90
KRW 🇰🇷	2.63	2.64

ЗУРХАЙ

2023.07.18 /МЯГМАР ГАРАГ/
БИЛГИЙН ТООЛЛЫН 1

ЗУНЫ АДАГ ШАРАГЧИН ХОНЬ САР
ЗУРГААН ЦАГААН МЭНГЭТЭЙ УЛААГЧИН ҮХЭР ӨДӨР

Үс засуулбал:
Нас ахар болно
НАРАН УРГАХ, ШИНГЭХ:
05.11-20.45
Барилдлага:
Арвидах
ШҮТЭН БАРИЛДЛАГА:
Сэрэхүй

Тухайн өдөр могой, морь, гахай, хулгана жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр идээ, хувцас хунар олдох, худалдаа наймаа хийх, эд зүйлс өгөлцөж авах, өглөг өгөх, хөрөнгө цацах, эдийн тэнгэр тахиулах, шид бүтээл үйлдэхэд сайн, амраг лугаа золгох, авшиг авах, ус гатлах, угаах зэрэгт сайн. Баруун нүд татвал садан ирэх, зүүн нүд татвал баярлах, баруун чих хангинавал гутамшиг болох, зүүн хангинавал завхарсныг сонсож цочих, бие татвал өмнө зүгээс зочин ирэх, хөл татвал хэрүүл гомдол болно.

ШИНЭ ДЭД АХЛАГЧ НАРЫН ЗАМ МӨР НЬ ТЭГШ ДҮҮРЭН БАЙХЫГ ЕРӨӨЛӨӨ



Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга хурандаа Д.Өлзийбаяр нар өнөөдөр бүлээн авч уулзаж, үүрэг чиглэл болоод зөвлөгөө захиасыг хүргэлээ.

Хурандаа Ц.Буяндэлгэр томилот өвөртөлсөн шинэ боловсон хүчинд хүн байх тухай, цэргийн алба хаагч ямар байх тухай мэдээлэл өглөө. "Та бүхэн нэг талаар азтай залуус. Богино хугацааны эрчимжүүлсэн сургалтад хамрагдаж, ахлагч хэмээх энэ сайхан албанд орж чадсанаараа бахархах ёстой. Ахлагч гэдэг цолыг нь зүүснээрээ болчихдоггүй юм. Харин зогсолтгүй суралцаж, мэргэшиж, өөрийгөө дайчилж байж мэргэжлийнхээ эзэн болж гялалзах зам мөр та бүхний өмнө бий. Хүний ажил

амьдралын анхны гараа гэдэг их чухал. Томилогдож очсон нэгтгэл, ангидаа залуу хүний ёсоор цог жавхаатай, цовоо сэргэлэн байж, өгсөн үүрэг даалгаврыг нь мадаггүй биелүүлэхэд анхаар. Хоёрдугаарт, нэгэнт цэргийн амьдралыг сонгосны хувьд хувийнхаа ажил, амьдралыг зөв төлөвлөж сурах хэрэгтэй. Зөв эр хүн бай, хуримтлал үүсгэ, ачаалал даах чадварыг өөртөө бий болго, албаараа бахархах үзэл та бүхний цээжин дотор багтаж ядан байх ёстой" гээд шинэхэн дэд ахлагч нарын зам мөр нь тэгш дүүрэн байхыг ерөөв. Үүний дараа командлалын Хүний нөөцийн хэлтсээс томилогдсон бүрэлдэхүүнтэй уулзаж, анхаарах асуудлын талаар мэдээлэл хүргэж, ажил албанд нь амжилт хүссэн юм.



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн "Ахлагчийн хөгжлийн төв"-ийг түшиглэн явагдсан мэргэжлийн ахлагч бэлтгэх сургалтад хамрагдсан бүрэлдэхүүн Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад томилогдлоо. Зэвсэгт хүчний 10 гаруй нэгтгэл, ангид цэргийн гэрээт болон хугацаат алба хааж байсан залуус өөрсдийн хүсэл мөрөөдлөөр мэргэжлийн ахлагч

бэлтгэх эрчимжүүлсэн сургалтад хамрагдаж, амжилттай дүүргэсэн юм. Тэгвэл тэдний тодорхой хэсэг нь Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн нэгтгэл, ангид томилогдсон бөгөөд шинэхэн дэд ахлагч нарыг Хуурай замын цэргийн штабын дарга хурандаа Ц.Буяндэлгэр болон командалын

ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИД ИХ СУРГУУЛЬД ЭЛСЭН ОРЛОО



Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн байлдагчид хугацаат цэргийн алба хаах хугацаандаа Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлдэн амжилттай өгч, улмаар Дотоод хэргийн их сургууль, Үндэсний Батлан хамгаалахын Их сургуульд тус тус элсэн орлоо.

Баяр наадмын өмнөхөн тэд Улаанбаатар хотыг зорин бие бялдар, сэтгэл зүй, ирүүл мэндийн шалгалтуудыг өгч мотобуудлагын ротын IV салааны ахлах байлдагч Б.Лхагвадорж Дотоод хэргийн их сургуулийн "Шүүхийн шийдвэр гүйцэтгэл", III салааны ахлах байлдагч Э.Жамъянсүрэн Батлан хамгаалахын их сургуулийн "Кибер аюулгүй байдал"-ын ангид суралцах эрхийн бичгээ гардан аваад ирсэн юм.

Ахлах байлдагч Б.Лхагвадорж, Э.Жамъянсүрэн тэй ярилцахад "Бид хоёрыг ангийн захирагч, ротын удирдлагууд Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлдэх бүрэн бололцоогоор хангаж өгсөн. Тийм ч учраас бид хоёр шалгалтаа амжилттай өгч хүссэн сургуульдаа тэнцээд ирлээ. Их сургуульд элсэх бүх нөхцөл, боломжоор хангаж, тусалж дэмжсэн Зэвсэгт хүчний 339 дүгээр ангийн удирдлага, ротын захирагч, ротын хамт олон болон ангийн бие бүрэлдэхүүндээ баярлаж талархсанаа илэрхийлье" гээд мөрдэс нэгт дайчдадаа амжилт хүсч, хугацаат цэргийн алба нь боломжоор дүүрэн байдгийг онцоллоо.

Дэслэгч М.АНХЖАРГАЛ



КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 690,999,234

Эдгэрсэн

Нийт: 663,800,903

Нас барсан

Нийт: 6,903,596

Цахим шууданд

Хурандаа Ц.Буяндэлгэр: АЛБААРАА БАХАРХАХ ҮЗЛЭЭР ӨӨРИЙГӨӨ ЦЭНЭГЛЭЖ ЯВААРАЙ



хэмээх энэ сайхан албанд орж чадсанаараа бахархах ёстой. Ахлагч гэдэг цолыг нь зүүснээрээ болчихдоггүй юм. Харин зогсолтгүй суралцаж, мэргэшиж, өөрийгөө дайчилж байж мэргэжлийнхээ эзэн болж гялалзах зам мөр та бүхний өмнө бий. Хүний ажил амьдралын анхны гараа гэдэг их чухал. Томилогдож очсон нэгтгэл, ангидаа залуу хүний ёсоор цог жавхаатай, цовоо сэргэлэн байж, өгсөн үүрэг даалгаврыг нь мадаггүй биелүүлэхэд анхаар. Хоёрдугаарт, нэгэнт цэргийн амьдралыг сонгосны хувьд хувийнхаа ажил, амьдралыг зөв төлөвлөж сурах хэрэгтэй. Зөв эр хүн бай, хуримтлал үүсгэ, ачаалал даах чадварыг өөртөө бий болго, албаараа бахархах үзэл та бүхний цээжин дотор багтаж ядан байх ёстой" гээд шинэхэн дэд ахлагч нарын зам мөр нь тэгш дүүрэн байхыг ерөөв.

Үүний дараа командлалын Хүний нөөцийн хэлтсээс томилогдсон бүрэлдэхүүнтэй уулзаж, анхаарах асуудлын талаар мэдээлэл хүргэж, ажил албанд нь амжилт хүссэн юм.



Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн "Ахлагчийн хөгжлийн төв"-ийг түшиглэн явагдсан мэргэжлийн ахлагч бэлтгэх сургалтад хамрагдсан бүрэлдэхүүн Зэвсэгт хүчний нэгтгэл, ангиудад томилогдлоо. Зэвсэгт хүчний 10 гаруй нэгтгэл, ангид цэргийн гэрээт болон хугацаат алба хааж байсан залуус өөрсдийн хүсэл мөрөөдлөөр мэргэжлийн ахлагч бэлтгэх эрчимжүүлсэн сургалтад хамрагдаж, амжилттай дүүргэсэн юм. Тэгвэл тэдний тодорхой хэсэг нь Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн нэгтгэл, ангид

томилогдсон бөгөөд шинэхэн дэд ахлагч нарыг Хуурай замын цэргийн штабын дарга хурандаа Ц.Буяндэлгэр болон командлалын Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн дарга хурандаа Д.Өлзийбаяр нар өнөөдөр хүлээн авч уулзаж, үүрэг чиглэл болоод зөвлөгөө захиасыг хүргэлээ.

Хурандаа Ц.Буяндэлгэр томилот өвөртөлсөн шинэ боловсон хүчинд хүн байх тухай, цэргийн алба хаагч ямар байх тухай мэдээлэл өглөө. "Та бүхэн нэг талаар азтай залуус. Богино хугацааны эрчимжүүлсэн сургалтад хамрагдаж, ахлагч

СЭТГЭЛ ЗҮЙН ХАТУУЖИЛ ОЛГОЖ, АЙДСАА ДАВАН ТУУЛАХ ЧАДВАРУУДЫГ ЭЗЭМШҮҮЛЖЭЭ



"Оюутан цэрэг-2023" сургалт амжилттай явагдаж байна. Монгол Улсын Засгийн газрын шийдвэрээр энэ жил их, дээд сургууль, МСҮТ-ийн суралцагч нарын эрэлт хэрэгцээнээс хамааран 1500 оюутан цэрэг болгон нэмэгдүүлсэн бөгөөд ҮБХИС-ийн Шархад дахь Сургалтын төв, Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн Сургалтын төв болон аймгуудад бүсчилсэн хэлбэрээр цэргийн мэргэжил олгох сургалтууд явагдаж байна.

Тодруулбал, баруун, зүүн, хангай, говийн бүсийн аймгаасаа хамааран Зэвсэгт хүчний 123, 167, 186, 327, 330 дугаар ангиудын материаллаг баазыг түшиглэсэн сургалтууд явагдаж байгаа билээ. Ингэхдээ нэгдсэн төлөвлөгөөний дагуу бие бялдар, сэтгэл зүйн бэлтгэлжилтийн түвшинг дээшлүүлэх сургалтууд, соёл хүмүүжил, яриа таниулга, нөлөөллийн арга хэмжээнүүд явагдаж, оюутан цэргүүдийн идэвх оролцоо ч өндөр байгаа юм.

Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн

Сургалтын төвийг түшиглэн явагдаж байгаа сургалтын нэг өдөртэй нийслэлийн Баянгол дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга хурандаа Л.Цэрэгбаяр, доктор, профессор, бэлтгэлд байгаа хурандаа П.Нарангэрэл нар танилцаж, "Монгол Улсын тусгаар тогтнол" сэдвээр яриа таниулга хийсэн байна.

Мөн Зэвсэгт хүчний 327 дугаар ангийнхан оюутан цэргүүдийнхээ гар нийлэмжтэй хамтын ажиллагааг бэхжүүлэх, нөхөрсөг уур амьсгалыг бэхжүүлэх, эх орны тусгаар тогтнолын үнэ цэнийг ойлгуулах хүрээнд соёл хүмүүжлийн ажлуудыг тасралтгүй явуулж байгаа ажээ.

Түүнчлэн Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн материаллаг баазыг түшиглэн явагдаж байгаа сургалтаар оюутан цэргүүдэд сэтгэл зүйн хатуужил, бэлтгэл олгох, айдсаа даван туулах чадварыг эзэмшүүлэх зорилгоор 6 үе шаттай хичээлийг тус тус бэлтгэн явуулсан байна.

Гэрэл зураг түүх өгүүлнэ



"Оюутан цэрэг-2023" 10км-ийн маршаар..

НҮБ-ЫН МЕДАЛЬ ГАРДУУЛАХ АЖИЛЛАГААГ ЁСЛОЛ ТӨГӨЛДӨР ТЭМДЭГЛЭЛЭЭ



БНӨСУ-д явагдаж байгаа "UN-MISS" ажиллагааны Монгол Улсын Зэвсэгт хүчний 12 дугаар ээлжийн цэргийн багаас алслагдсан баазуудад үүрэг гүйцэтгэж буй бүрэлдэхүүнд НҮБ-ын медаль гардуулах ёслолын ажиллагааг энэ сарын 14-ний өдөр ёслол төгөлдөр зохион байгууллаа.

Ёслолын арга хэмжээний хүндэт зочдоор Юнити секторын штабын дарга дэд хурандаа Прасад Анил Титэ, Рувенг засаг захиргааны бүсийн дарга ноён Стефано Виэю Ди Миалэк, Юнити секторын хэвлэлийн албаны дарга Петер Бэтмен, Үндэсний аюулгүй байдлын зөвлөх ахмад Румано Пол Гаси, Мотобуудлагын XII батальоны захирагч хурандаа Н.Эрдэнэбаяр болон НҮБ-ын ажиглагч, штабын офицерууд, зочид төлөөлөгчид оролцож, Юнити секторын штабын дарга дэд хурандаа Прасад Анил Титэ, батальон захирагч хурандаа

Н.Эрдэнэбаяр нар бие бүрэлдэхүүнд баяр хүргэж, амжилт хүслээ.

Ёслолын ажиллагаанд оролцож буй хүндэт зочдод Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багийн бие бүрэлдэхүүний зүгээс үндэсний урлагийн үзүүлбэрүүд, гардан тулааны болон жагсаалын үзүүлэх тоглолтыг үзүүлсэн юм.

Энэ ташрамд тус рот нь үндсэн үүрэг гүйцэтгэлтээс гадна ажиллагааны газар оронд төв замаас баазын байрлал хүртэлх авто замыг засварлах, хүүхэд багачуудын сурч боловсрох, тоглож наадах орчин нөхцлийг сайжруулахад санаачлагатай ажиллан орон нутгийн удирдлагуудтай нягт хамтран ажиллаж иргэн-цэргийн харилцааг улам өргөжүүлж Юнити сектор төдийгүй НҮБ-ын "UNMISS" ажиллагаанд үлгэр жишээ болсоор байна.

Ахлах дэслэгч Л.ТҮМЭНДЭЛГЭР

АЛТАНБУЛАГИЙН ОЮУТАН ЦЭРГҮҮД ОНЧ МЭРГЭН, ОНЦ БУУДЛАА



Зэвсэгт хүчний 119 дүгээр ангийн Сургалтын төвд явагдаж байгаа "Оюутан цэрэг-2023" цэргийн мэргэжил олгох сургалтынхан төлөвлөгөөний дагуу хоёрдугаар шатны буудлагын дасгалыг амжилттай зохион байгуулж явууллаа.

Энэ удаа бүх төрлийн буудлагын зэвсгээр дасгалыг боловсруулж явуулсан бөгөөд дайчид төрөл бүртээ онч мэргэн, онц буудаж байсан нь сургалт зохион байгуулагчдын талархлыг хүлээсэн юм.

Тодруулбал, автоматын буудлагаар байлдагч Э.Бат-Өлзий, О.Батбаатар, А.Төртүшиг, танк эсэргүүцэгч гар гранатмётээр байлдагч М.Үйлстөгөлдөр, Б.Дорждагва, Б.Ганболд, мэргэн

буудлагчийн винтовоор байлдагч З.Төрболд, М.Мөнхбаясгалан, А.Хангалдорж, тасгийн пулемётээр байлдагч Г.Зенбилэг, З.Очгэрэл, Э.Эрдэнэбат, О.Чинзориг нар онц буудаж, бусдыгаа тэргүүлэв.

Алтанбулаг дахь оюутан цэргүүдэд сургалтын төлөвлөгөөний дагуу цэргийн 11 төрлийн мэргэжил эзэмшүүлэхээр сургалт бэлтгэлийг тасралтгүй явуулж байна. Үүний сацуу тэдний сэтгэл зүйн хатуужил, бэлтгэлжилтийг дээшлүүлэх, айдсаа даван туулахад чиглэсэн хичээл болон хувь хүний хүмүүжил, төлөвшил, нөхөрсөг хамт олонч харилцаанд сайнаар нөлөөлөхүйц соёл хүмүүжил, спортын арга хэмжээг зохион байгуулсаар байгаа юм.

Дэслэгч Б.ТЭНГИС

